



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

*Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын захиалгаар
Дуут сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан*



**ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, СУМ ХӨГЖҮҮЛЭХ
ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

Ховд хот

2016 оны 10 сар

Агуулга

Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	
ҮАГ-ын харьяа Ховд аймгийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл	
Тэргүүлэх аудитор Л.Галбадрах		3
Аудитын менежер А.Цэцэгсүрэн		3
Ахлах аудитор Д.Нарантуул		4
Шинжээч Ц.Гантулга		5
Шинжээч Ц.Аззаяа		6
	Бүлэг 1.Төсөвт байгууллагуудын орлого бүрдүүлэлтийн талаар	
	Орон нутгийн орлогын бүрдүүлэлтэнд тавих хяналт сулаас татварын орлого тасарч байгаад дүгнэлт хийж сумын ИТХ-аар орлогыг нэмэгдүүлэх тогтоолуудыг батлуулж мөрдөх шаардлагатай байна.	8
	Бүлэг 2. Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалтын талаар	10
2016 оны 10 дугаар сар	Төсвийн төвлөрүүлэн захирагч нь татварын орлогоор 19,9 сая, санхүүгийн дэмжлэгээр 285,7 сая, ОНХС-гийн санхүүжилтээр 83,0 сая, СХС-гийн санхүүжилтээр 20 сая, СХС-гийн хүүгийн орлого болон зээлийн төлбөрийн авлагаар 26,9 сая, бүгд 435,5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 418,9 сая төгрөгийн зарлагын санхүүжүүлсэн байна.	10
Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.audit.gov.mn		11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу.	Орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглах түрээсийн гэрээ байгуулж өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна	13
	Бүлэг 3. Дотоод хяналтын талаар	13
ХАЯГ:	Сумын орон нутгийн төсөвт байгууллагууд 2015 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэн ажилласан боловч санхүү бүртгэлээр тавих дотоод хяналт төрийн өмчийн хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.	14
Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар	Аудитын дүгнэлт	15
Ховд аймгийн Аудитын газар	Аудитын зөвлөмж	16
3 давхар	Тэргүүлэх Аудиторын тушаал	18
	Акт албан шаардлагын товчоо	21
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:	

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ААГ	Аймгийн аудитын газар
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НДШ	Нийгмийн Даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь Хүний Орлогын албан татвар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Мян.төг	Мянган төгрөг

БҮЛЭГ 1. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙН ТАЛААР

Дуут сум нь 1951 хүн амтай, 512 өрхтэй, 133,3 мянган толгой малтай, 214,7 мянган га газар нутагтай, улсын нийслэл Улаанбаатараас 1510 км алслагдсан, аймгийн төвөөс 75 км алслагдсан, орон нутгийн чанартай зам харгуйтай.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага ИТХ-тай, төрийн захиргааны байгууллага ЗДТГазар, нийгмийн үйлчилгээний салбар сумын Эрүүл мэндийн төв, 12 жилийн ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв гэсэн төсөвт байгууллагуудтай, ХААН, Төрийн банк, Холбоо, шатахуун түгээх станцууд зэрэг аж ахуйн нэгжтэй. Эрчим хүчний байнгын эх үүсвэр, үүрэн холбооны Мобиком, Скайтель, Жи-мобиль, Юнителийн сүлжээнд холбогдон төрийн үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх үүрэгтэйгээр ажиллаж байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь татварын орлогоор 19,9 сая, санхүүгийн дэмжлэгээр 285,7 сая, ОНХС-гийн санхүүжилтээр 83,0 сая, СХС-гийн санхүүжилтээр 20 сая, СХС-гийн хүүгийн орлого болон зээлийн төлбөрийн авлагаар 26,9 сая, бүгд 435,5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 418,9 сая төгрөгийн зарлагын санхүүжүүлсэн байна.

Харин тусгай зориулалтын шилжүүлгийн 4 байгууллагууд 898,1 сая төгрөгийн санхүүжилтийн төсөв батлуулж 865,8 сая төгрөгийн төсвийн санхүүжилт, өөрийн орлого бүрдүүлж санхүүжилтийг 27,1 сая төгрөгийн санхүүжилт дутуу, өөрийн орлогыг 4,1 сая төгрөгөөр дутуу биелүүлжээ.

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцаас сумын төрийн санд олгож Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Харин сум хөгжүүлэх санд 69,5 сая төгрөгийн орлого бүрдүүлж 77,5 сая төгрөгийн зээл, бусад зардлыг санхүүжүүлсэн бол, ОНХС-гийн санхүүжилтээр 103,1 сая төгрөгийн орлого бүрдүүлж 84,1 сая төгрөгийн зардал санхүүжүүлжээ.

Сумын нийт дүнгээр тайлант оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 10,7 сая төгрөг байсан бол оны эцэст 0,8 сая төгрөг болжээ.

	ᠤᠨᠢᠯᠡᠭᠦᠳᠡᠰᠡᠨ		
ᠣ᠋᠗ᠣ᠔ᠠᠳᠣᠶᠢ ᠲᠥᠪᠴᠡ	ᠣ᠋ᠷᠡ᠎ᠠᠭᠡᠳᠡᠰᠡᠨ	ᠠᠵᠡᠳᠡᠬᠡᠳᠡᠰᠡᠨ	ᠴᠣᠳᠤᠵᠤ
ᠤᠨᠢᠯᠡᠭᠦᠳᠡᠰᠡᠨ	323,817,500	305,672,604	18,144,896
ᠣᠳᠣᠩᠭᠡᠨ ᠲᠥᠪᠴᠡ	43,067,600	19,922,704	23,144,896
ᠣ᠗ᠣ᠔ᠠᠳᠣᠶᠢ ᠤᠨᠢᠯᠡᠭᠦᠳᠡᠰᠡᠨ	39,100,000	19,055,400	20,044,600
ᠣᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ ᠲᠥᠪᠴᠡ ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	11,900,000	4,107,125	7,792,875
ᠣ᠗ᠣ᠔ᠠᠳᠣᠶᠢ ᠲᠥᠪᠴᠡ ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	-	-	-
ᠤᠨᠢᠯᠡᠭᠦᠳᠡᠰᠡᠨ ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	900,000	354,000	546,000
ᠣ᠗ᠣ᠔ᠠᠳᠣᠶᠢ ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	4,000,000	2,873,000	1,127,000
ᠣ᠗ᠣ᠔ᠠᠳᠣᠶᠢ ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	7,000,000	880,125	6,119,875
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	700,000	724,000	(24,000)
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	-	-	-
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	700,000	724,000	(24,000)
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	26,500,000	14,224,275	12,275,725
ᠣᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	2,000,000	548,900	1,451,100
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	800,000	-	800,000
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	20,000,000	11,889,975	8,110,025
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	-	-	-
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	2,500,000	1,368,800	1,131,200
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	400,000	296,600	103,400
ᠣᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	800,000	120,000	680,000
ᠣ᠗ᠣ᠔ᠠᠳᠣᠶᠢ ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	2,605,000	867,304	1,737,696
ᠣᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	605,000	330,000	275,000
ᠣᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	2,000,000	537,304	1,462,696
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	1,362,600	-	1,362,600
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	1,362,600	-	1,362,600
ᠠᠵᠡᠳᠡᠫᠡᠳᠡᠰᠡᠨ	280,749,900	285,749,900	(5,000,000)

Орон нутгийн орлогын бүрдүүлэлтэнд тавих хяналт сулаас татварын орлого тасарч байгаад дүгнэлт хийж сумын ИТХ-аар орлогыг нэмэгдүүлэх тогтоолуудыг батлуулж мөрдөх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

Сумын дүнгээрээ төсвийн санхүүжилтийг баталсан дүнгээс 61,5 сая төгрөгөөр дутуу авч, өөрийн орлогыг 4,7 сая төгрөгөөр тасалжээ.

Тус сумын төсөвт байгууллагууд 2015 онд Засгийн газар, аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын мөрийн хөтөлбөр болон бусад агентлаг, хэлтэс, сумын баг, албан байгууллагуудтай уялдуулан жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан биелэлтийг сар, улирал бүрээр тооцож ажилласан байна.

Сумын нийт дүнгээрээ 1318,1 сая төгрөгийн төсвийн санхүүжилт, 6,1 сая төгрөгийн өөрийн орлого бүрдүүлэхээр батлуулж төсвийн санхүүжилтээр 1256,6 сая төгрөгийн санхүүжилт авч, 1,4 сая төгрөгийн өөрийн орлого бүрдүүлж санхүүжилтийг 61,5 сая төгрөгөөр дутуу авч өөрийн орлогыг 4,7 сая төгрөгөөр тасалжээ.

2015 он Байгууллагын нэр	Баталсан төсөв/ сая.төг/ өөрийн орлого Дүн			Гүйцэтгэл/ сая.төг/ өөрийн орлого Дүн			Зөрүү / сая.төг/ өөрийн орлого Дүн		
	Төсөв	орлого	Дүн	Төсөв	орлого	Дүн	Төсөв	орлого	Дүн
Хо. Дуут ИТХ	42.5		42.5	40.3	0	40.3	2.2	0.0	2.2
Хо. Дуут ЗДТГ	279.9	0.6	280.5	267.2	0.3	267.5	12.7	0.3	12.4
Хо. Дуут ОНХС	103.1		103.1	84.4	0	84.4	18.7	0.0	18.7
Хо. Дуут ЕБС	466.7	0.1	466.8	453.4	0	453.4	13.3	0.1	13.3
Хо. Дуут СЕБ	155.7		155.7	148.1		148.1	7.6	0.0	7.6
Хо. Дуут Соёлын төв	57	5.0	62.0	51.5	0.7	52.2	5.5	4.3	4.8
Хо. Дуут Эрйл мэндийн төв	213.2	0.4	213.6	211.70	0.4	212.1	1.5	0.0	1.1
Нийт	1,318.1	6.1	1,324.2	1,256.6	1.4	1,258.0	61.5	4.7	60.1

2.1. Сумын ИТХ-ын үйл ажиллагааны талаар:

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг чадварлаг, нээлттэй, ил тод болгон төлөвшүүлж, хөгжлийн шинэ түвшинд хүргэн иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд тулгуурлан, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх тасралтгүй үйл ажиллагаатай, хууль эрхзүйн орчныг бүрдүүлэн сумын ард иргэдийн аж амьдралыг дээшлүүлж ая тух ажиллаж, амьдрах нөхцөл бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажиллажээ.

2015 онд ИТХ-ын хуралдааныг 2 удаа хийж хийж дэвшүүлсэн ханган биелүүлж, тэргүүлэгчдийн хуралдааныг 11 удаа хийж ИТХТ-ын 23 тогтоол гарсан байна. Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Сумын Хурлын даргатайгаа бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээ байгуулан ажилласан байна.

Сумын ИТХ-аар санхүүгийн алба, шилэн дансны хуулийн хэрэгжилт, сум хөгжүүлэх сангийн зээлийн зарцуулалтанд хяналт хийгээгүй байгаагаас үзэхэд сумын иргэдийн төлөөлөгчдийн хураас тавих хяналт хангалтгүй байна.

Тус сумын ИТХ-ын тайлан мэдээ, хэрэгжүүлсэн ажлаас үзэхэд сумын ИТХ-ын ажлын алба нь суманд хэрэгжүүлэх хяналтын чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн байна. Цаашид сумын орон нутгийн орлогын бүрдүүлэх талаар санаачлага гарган ажиллах, ИТХ-аар орон нутгийн шинж чанартай орлого нэмэгдүүлэх тогтоолуудыг шинэчлэх, орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалтанд тавих хяналтыг сайжруулах, төрийн албан хаагчдын ажил үүргийн биелэлтэнд тавих хяналтыг нэмэгдүүлэх зөвлөмж өглөө.

Аудитаар ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил илэрсэнгүй.

2.2 Сумын Засаг даргын үйл ажиллагааны талаар:

Сумын ЗДТГ нь Шинэчлэлийн газар болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж тэргүүний сум болох зорилтыг дэвшүүлэн иргэдийнхээ амьдрах орчинг сайжруулах зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Сумын Засаг даргын 2012-2016 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 80,6 хувийн биелэлттэй, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биеллэлт 85 хувьтай тус тус дүгнэгджээ.

Төрийн үйлчилгээг ард иргэд, албан байгууллагуудад ил тод шуурхай хүргэх, төр ард иргэдийн холбоог бэхжүүлэх зорилт тавин ажилласан. Нийт 25 орон тоотой ажиллахаас, гүйцэтгэлээр 25 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан.

ЗДТГ-ын дарга нь болон ЗДТГ-ын ажилчид тайлант онд бүтээгдхүүн нийлүүлэлт үр дүнгийн гэрээ байгуулан дүгнэсэн байна.

Тус сум нь хөдөөгийн 3, төвийн 1 бүгд 4 багтай нийт 1,9 мянган хүн амд багийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Багийн дарга нар тайлант онд багийн Засаг дарга нь бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээ байгуулан жилийн эцэст ажлаа дүгнүүлэн, тухайн жилд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулан ажилласан байна.

Сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд сайжруулах шаардлагатай анхаарал хандуулах дараах асуудлууд байна

- ЗДТГ нь төсвөөс цаг бүртгэлийн программ хангамж ашиглан цаг бүртгэж байгаа ч тайлант онд 1 ч хүний цалин хасаагүй, төрийн албан хаагчийн цаг ашиглалтанд тавих хяналт хангалтгүй байна.
- Байгууллагын ажилчдын цалингийн картанд гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй байна. Мөн шатахууны зардлыг зөвшөөрлийн бичгээр ажлын зориулалт бичин зарлагдсан боловч байгууллагын автомашины замын хуудасны тооцоог Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 тоот /Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм/ тушаал үндэслэн тооцоо бодохыг зөвлөмж болголоо.
- Нэр бүхий ажилчдын цалинг илүү тооцож олгосон, амралт цалин давхардуулан олгосонтой холбоотой 478509 төгрөгийн акт бичлээ.
- 2014 оны 12 сард СХС-гаас 2,0 сая төгрөг, 2015 оны 1 сард 1,0 сая төгрөгийн авс тус тус худалдан авчээ. 2015 онд өвсний үнэ 482,0 мянган төгрөгийг СХС-гийн дансанд төвлөрүүлсэн боловч дутуу 2518000 төгрөгийн тооцоо хийгээгүй байна. Мөн Эе эвийн хүч ХХК-д шилжүүлсэн павилоны үнэ орлогод аваагүй, захирамжаар зарцуулсан хөрөнгийн анхах шатны баримт дутуу зэрэгтэй холбоотой хавсралтанд заасан албан шаардлага бичлээ.
- 2015 онд 90,6 тн нүүрсийг 8,8 сая төгрөгөөр худалдан авчээ. Оюу хайрхан ХХК-наас худалдан авсан 1,9 сая төгрөгийн 20 тн нүүрсийг ажилдчдад тушаал шийдвэргүйгээр олгосон тул албан шаардлага бичлээ. Үлдэх 70,6 тн нүүрсний зарцуулалтын тайлан өдөр бүрээр, галч нарын нүүрс

зарцуулалтаар жагсаалт үйлдэн зарлагдаж нүүрсний зарцуулалтанд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

- Сумын Засаг даргын тамгын газрын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өргүй байсан бол 2015 оны эцэст 4,4 сая төгрөгийн өр төлбөртэй гарчээ. Тус өрийн 2,4 сая НДШ, 1,8 сая татварын өртэй байна. 2015 оны жилийн эцэст 5 хүнтэй холбоотой 3,1 сая төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагатай байна. Иймд авлагыг тайланд өглөг, авлагыг бүрэн барагдуулан ажиллах зөвлөмж өглөө.
- Тайлант онд сумын Амьжиргаа дэмжих зөвлөл 28 удаа хуралдаж 34 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, нөхцөлт мөнгөн тэтгэмж, жирэмсэн амаржсны тэтгэмж, алдарт эхийн одон, ахмад настан болон ХБИ- д эмчилгээнд явж ирсний замын зардал, рашаан сувилалын зардал, түлшний үнийн хөнгөлөлтөд 425 иргэнд 163,9 сая төгрөгийг олгожээ. Хүнс тэжээлд олгох бэлтгэн нийлүүлэгч компанийг харьцуулалтын аргаар сонгон “Сэргэлэн охин Хулан” хоршоо шалгарч гэрээ байгуулан хүнсний эрхийн бичгээр 7 өрхийн 42 иргэнд 4,6 сая төгрөгний хүнсний талон олгосон байна. Аймгийн Нийгмийн халамжийн хэлтсийн дотоод хяналтаар 4 хүнтэй 434,3 мянган төгрөгний анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүйтэй холбоотой зөрчил илэрснийг засаж залруулах зөвлөмж өглөө.
- Тамгын газраас нүүрс, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтэнд тендер зарлаж хэрэгжүүлж байгаа боловч нийлүүлэгч компаниудын үнийн санал өмнөх онуудын худалдан авсан үнээс буурч арвилан хэмнэлт үр өгөөж бий болоогүй байгаа тул гэрээний үнийг бууруулах, шаардлагатай тохиолдолд бусад ижил чанар бүхий хямад үнийг санал болгож буй компаниудаас худалдан авалт хийж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг сайжруулах зөвлөмж өглөө.
- Засаг даргын захирамжаар гаргаж буй зарим зардлын тушаалаар зарцуулсан зарцуулалтын анхан шатны баримт дутуу байгааг анхаарч гүйцэтгэлийн тайланг хавсаргаж анхан шатны баримтын бүрдэлтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтанд тавих хяналт сул байна.

- Тус сумын машин тоног төхөөрөмж дансанд бүртгэлтэй 3654,2 мянган төгрөгний анхны өртөгтэй , үлдэх өртөггүй, үлдэх өртөггүй 2002 онд ашиглалтанд орсон 2 ширхэг **бүгд 7308,4** төгрөгний үнэтэй Камацу-60 дизель станц байгууллагын хөрөнгийн бүртгэлд байгаа боловч оршин байхгүй байгаа тул албан шаардлага бичлээ.
- Хөрөнгө оруулалтаар ирсэн хог тээврийн тракторыг иргэн Х.Мандах,М.Ганзориг нар ашиглан гэрээ байгуулж сард төлөх 10,0 мянган төгрөгийг төлөөгүй, иргэн Энхбадамтай байр түрээслэх гэрээний төлбөрийг төлүүлээгүй тул тус бүр 120,0 мянган төгрөгийн акт бичлээ.
- Цаашид орон нутгийн өмч ашиглаж байгаа бусад байгууллагуудтай гэрээ байгуулан гэрээний үүргийн биелэлтийг жил бүр тооцох, хөрөнгийн

ашиглалтанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал: Г.Хүрэлчулуунтай хийсэн хадлангийн талбай ашиглах гэрээг шинэчлэх, халуун ус худаг ашиглах гэрээг дахин хийж хэрэгжилтийг ханган үүрэг хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай байна.

- ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд байгаа ашиглалтгүй хөрөнгийг ялган байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг гаргаж холбогдох байгууллагад уламжлан хөрөнгийн ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

Аудитаар 15,890,809 төгрөгийн зөрчил илэрснээс 838,509 төгрөгийн төлбөрийн акт 15,052,300 төгрөгийн алдааг залруулах албан шаардлага бичлээ.

2.3 Сум хөгжүүлэх сангийн талаар

Сум хөгжүүлэх санд 2011 оноос хойш зээлийн эх үүсвэр бүрдэж 2015 оныг хүртэл 97 иргэнд 249,3 сая төгрөгийн зээл олгожээ. Харин 2015 онд 21 иргэнд 69,8 сая төгрөгийн зээл олгожээ.

Сумууд зээл авсан иргэд гэрээнд заасан хугацаанд зээлийн төлбөрийг төлөөгүй, зориулалт бусаар зээлийг ашигласантай холбоотой зээл авсан иргэдийг эвлэрүүлэн зуучлуулагчид өгч зээлийн төлбөрийг барагдуулж байгаа сайн турш байхад тус сумын ИТХ, ЗДТГ-аас энэ талаар ямар нэгэн арга хэмжээ хэрэгжүүлээгүй байгаас зээл, зээлийн хүүгийн төлбөр хугацаа хэтэрч сангийн хөрөнгийн эргэлтийг бууруулж байна.

Тус сангийн мөнгөн хөрөнгийн 2015 оны эхний үлдэгдэл 7,9 сая төгрөг байсан бөгөөд тайланд онд зээл, зээлийн хүүгийн төлбөрөөс 46,6 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлого бүрдүүлж 69,8 сая төгрөгийн зээл олгож 9577 төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2015 онд тус сангаас хяналтын хэрэгжүүлээгүйтэй холбоотойгоор зардал санхүүжүүлээгүй бөгөөд сум хөгжүүлэн сангийн журмын 1.8-д “Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна” гэж заасан байгааг цаашид хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

2015 онд олгосон 21 иргэний зээлийн хэрэгжилтийг хянахад 12 иргэний зээл нь тодорхой хэмжээнд улирлын чанартай хэрэгжиж гэрээр оёдол үйлдвэрлэн, цагаан идээ хийж байгаа бол үлдэх 9 иргэн зээлийг зориулалтын дагуу ашиглахгүй байна. Үүнд: У.Цогзолмаа, Ж.Батаа, Л.Нарангэрэл, Ж.Баянмөнх, Ж.Чимэд-Очир, Б.Пүрэвсүрэн, Д.Одонтуяа, Д.Ариунболд, Ц.Нямсүрэн нарын зээл зориулалт бусаар ашиглаж суманд ЖДҮ эрхлээгүй байна.

Мөн зээл олгосон иргэдтэй байгуулсан гэрээний хавсарлалтанд заасан зээлийн гэрээ шинэчлэн байгуулж эргэн төлөлтийн хуваарьт үндсэн зээлийн төлбөрийг сард жигд хуваан гэрээ хийх шаардлагатай байна.

2016 оны 9 сарын 30-ны байдлаар 197,7 сая төгрөгийн зээлийн төлбөр хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь 2016 оны 3 сарын 14-ны өдрийн 153 тоот Засгийн газрын тогтоолын СХС-гийн журмын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Сум хөгжүүлэх зээлийн эх үүсвэр бүрдэж орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх нөөц байгаа хэдий ч өмнөх зээл авсан иргэд төлбөрөө төлөөгүйтэй тул шүүхэд өгч дараагийн ЖДҮ иргэдэд олгон зээлийн эргэцийг сайжруулах шаардлагатай байна.

2.4 Орон нутгийн Хөгжлийн сангийн талаар:

2015 онд ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар нийт 11 ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 5 ажлыг анхны тогтоолоос нэмж. Анх баталсан 3 ажлыг хэрэгжүүлэхгүйгээр тайланд онд 13 ажлыг хэрэгжүүлжээ. Нийт хийгдсэн ажлуудыг шууд гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байгаас үзэхэд худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт, ОНХС-гийн журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Сумын ИТХ-ын хуралдаанаар 01/02 тоот тогтоолоор анх 131,7 сая төгрөгийн санхүүжилт баталж улмаар санхүүжилт танагдсантай холбоотой тодотгол хийгдэн 101,7 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 84,4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч зарцуулжээ. Аймгийн ОНХС-гаас 30,0 сая төгрөгийн санхүүжилт авч сумын сургуулийн халаалтын засварын ажлыг хэрэгжүүлсэн байна. Нийт ажлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

ДД	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Батлагдсан төсөв	тодотгосон төсөв	зөрүү
1	Хүүхэд залуучуудын талбай байгуулах	32,000.0	30,000.0	2,000.0
2	Зочид буудлын тохижилт		1,345.0	-1,345.0
3	Хадлангийн талбай хаших	900.0	300.0	600.0
4	Халуун ус	11,200.0	11,200.0	0.0
5	Шивэр баг ванн	300.0		300.0
6	Шивэр багийн төв	10,000.0		10,000.0
7	Эрүүл мэндийн төв	30,000.0		30,000.0
8	Төлөөлөгч нар тойрогтоо ажиллах	4,000.0	4,000.0	0.0
9	Малжуулах	3,000.0	2,000.0	1,000.0
10	Баяр наадам	5,300.0	5,300.0	0.0
11	Сумын дунд хугацааны хөтөлбөр ном хийх	5,000.0	5,000.0	0.0
12	сургуулийн халаалтын тогоо	30,000.0	45,000.0	15,000.0
13	Хөхбэлчир хад/талбай/байгаль хамгаалах/		3,000.0	-3,000.0
14	өв соёл		6,000.0	-6,000.0
15	3.8 Цагаанбургас баг/хүдгийн мотор, насос/		617.6	-617.6
16	3.9 Босго баг /хүдгийн цахилгаан халаалт/		600.0	-600.0
	Нийт	131,700.0	114,362.6	17,337.4
᠑	᠒ Урд оны давсан орлогоос	1,362.6	1,362.6	0.0

Аймгийн ОНХСгаас	30,000.0	30,000.0	0.0
Сумын ОНХС-гаас	100,337.4	83,000.0	17,337.4

Аудитын явцад хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг хянахад ОНХС-гийн санхүүжилтээр сум орон нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн бодит хэрэгцээт ажлууд хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал: Хүүхэд залуучуудын талбай байгуулах, сургуулийн халаалтын тогоо зэрэг ажлууд байна.

Харин 2015 оны төсөвт нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхижуулах хөтөлбөрт 4,0 сая төгрөг баталж 4,0 сая төгрөгийн зардлыг төлөөлөгч нарыг тойрогтоо ажиллуулах ажилд зарцуулжээ.

Нийт хэрэгжүүлсэн ажлуудыг багийн ИНХ-аар санал хэлэлцүүлж эрэмбэлсэн нэгтгэлгүй, иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй зочид буудлын тохижилтийн ажил, төлөөлөгч нар тойрогтоо ажиллах зардал санхүүжүүлсэн байна. Гэтэл нийт иргэдийн саналаар илүү санал авсан орон нутагт хийгдэх хэрэгцээт мал угаалгын ванн, хогийн цэг байгуулах, малжуулах хөтөлбөр, ундны ус зэрэг ажлууд тус онд хийгдээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын орон нутгийн хөгжлийн сангийн 43 тоот тогтоолын 4.2 дахь "Тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдээгүй байх", 4.4 дэхь "Аймаг, нийслэл, сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх", 4.6 дахь "ОНХС-гийн хөрөнгийг буцалтгүй тусламж дэмжлэгт зарцуулахгүй байх" зэрэг сэдвээр эзэрчсэн тул цаашид тус ажлыг санхүүжүүлэхгүй байх зөвлөмж өглөө.

2.5 Ерөнхий 12 жилийн Ерөнхий боловсролын сургуулийн талаар :

Сумын сургууль нь "Төрөлх хэлээрээ зөв ярьж бичдэг, үндэсний өв соёлоо дээдэлдэг, эрүүл харилцаатай, хөдөлгөөний эвсэлтэй хөгжсөн хамт олон болох, ЭЕШ-ийн дундаж оноог 550-д хүргэнэ" гэсэн зорилт тавин сургалт хүмүүжлийнхээ ажлыг зохион байгуулсан байна.

Дээрх зорилтын хүрээнд ном авьяас хөтөлбөрөөр Дээлтэй номтой монгол наадам, уртын дууны наадам, урианхай ардын туульс цуурын урлагийг өвлүүлэх, хөгжүүлэх өв соёлын танхим байгуулах, язгуур урлаг, яргуй наадмаар аймагт 5 дугаар байруудад төрлөөр аймагт тэргүүлсэн амжилт гарган ажилласан боловч аймгийн Боловсрол соёлын газрын 2015 оны ажлын үнэлгээгээр 15 дугаар байранд оржээ.

Тайлант онд аймгийн болон орон нутгийн Хөгжлийн сангаас сургуулийн халаалтын системийг шинэчлэх, сайжруулах, коридор 45,0 сая төгрөгний санхүүжилтээр засварын ажил хийгджээ.

Тайлант төсвөөс 476,1 сая, өөрийн орлогоор 0,1 бүгд 476,2 сая төгрөгнөөр батлагдаж гүйцэтгэлээр 453,4 сая төгрөгийн санхүүжилт авч улсын төсвөөс авах санхүүжилтээ 22,7 сая төгрөгөөр дутуу санхүүжил авчээ. Зардлын зүйлээр : гэрэл цахилгаан 1,1, түлш халаалт 2,3, цэвэр бохир ус, ном хэвлэлийн зардлуудыг хэмнэж, цалин 8,9, бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэлийн зардлуудыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Аудитын явцад багш ажилчдаас санал асуулга авахад Нийгмийн даатгалын дэвтэр зөрүүтэй бичдэг, дотуур байрны тогоочид зэргийн нэмэгдэл олгодоггүй,

дотуур байрны жижүүрт илүү цагийн хөлсийг бодож олгохгүй байгаа талаар санал ирүүлсэнтэй холбоотой тулгахад 2014 оноос хойш жижүүрт илүү цагийн хөлс болон зэргийн нэмэгдэлийг олгоогүй байна. Цалингийн сангийн төсөв хүрэлцээ байгаагаас олгоогүй гэж байгаа боловч ур чадварын нэмэгдлийг зарим багш ажилчдад 1-6 сараар хавтгайруулан хугацаатай олгож байгаа дутагдал байгаа тул цаашид санхүүгийн нөөцдөө тулгуурлан холбогдох нэмэгдлийг олгон зөвлөмж өглөө.

Үдийн цай хөтөлбөрийг Хүнхэрийн булаг ХХК-тай гэрээ байгуулан нийлүүлж байгаа боловч 2015 онд бүтээгдэхүүнийг Мэргэжлийн хяналтын газарт өгч шинжилгээний дүгнэлт гаргуулахгүйгээр нийлүүлсэн байгаас үзэхэд эмч, удирдлагын хяналт сул байна.

Сургуулийн биеийн тамирын заалны шал мөөгөнцөртөж муудсан тул сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон байна.

Аудитаар 3955,4 мянган төгрөгний зөрчил илэрснээс багш ажилчдын амралтын цалингийн дундажыг буруу тооцож 2015 оны амралтыг илүү дутуу олгосон, илүү цагийн хөлсийг зөрүүтэй бодож олгосон, аж ахуйн нэгж байгууллагуудаас зарим бараа материалыг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авсан, бэлнээр авсан мөнгөний үлдэгдэл дутсан зэрэгтэй холбоотой 2027,5 мянган төгрөгний төлүүлэх, 217,8 мянган төгрөгний буцаан олгох акт, 1710,0 мянган төгрөгний нүүрсийг төлсөн боловч орлогод авч эд хариуцагчийн тайлан гаргаагүйд албан шаардлага бичлээ.

2.6 Сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар :

Хүүхдийн цэцэрлэг нь 2015 онд “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх” гэсэн зорилт дэвшүүлэн зорилтоо ханган биелүүлэхийн тулд 4 бүлэгт 80 хүүхэдтэйгээр 14 багш ажилтантайгаар сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээг зохион байгуулжээ.

Ховд аймгийн хөгжлийн төлөө сангаас хөдөөгийн малчдын хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх ажлыг зохион байгуулахад шаардагдах 2 гэр, 1 бүлгийн тоглоом, нарны гэрэл, хөлдөөгч зэрэг хөрөнгө оруулалт хийжээ. Үүний үндсэнд хүүхэд бүрийг хөгжүүлэх боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд хувилбарт сургалтыг зуны улиралд хөдөөгийн 3 багт гэр цэцэрлэг ажиллуулах хэлбэрээр зохион байгуулсан үр дүнтэй ажил болжээ.

Төсвийн ерөнхийлэн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж оны эцэст дүгнүүлж 92 хувиар биелүүлж “А” үнэлгээ авчээ.

Төсвийн захирагч 13 багш ажилчидтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ хийж ажлынх нь үр дүнг тооцож зохих урамшил олгон ажилласан байна.

Тус цэцэрлэг нь төвлөрсөн төсвөөс 155,7 сая төгрөгийн санхүүжилт авах төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 148,1 сая төгрөг авч батлагдсан төсвөөс 7,6 сая төгрөг дутуу авсан байна.

Байгууллагад дээрхи ололттой талууд байгаа нь сайшаалтай боловч цаашид анхаарч ажиллах дараах зөрчил дутагдлууд илэрч байна.

- Багш ажилчдад үр дүнгийн урамшуулалыг хавтгайруулан олгосон, илүү цагийн хөлсийг олгосон, цагийн тооцоо бүрэн биш, илүү цагийн бүртгэл хөтөлж баталгаажуулаагүй байгаа зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өглөө.

- Няравын тайланг тухай бүр бодоогүй, хүүхдийн хоолны зарцуулалтанд тавих хяналт сул байна. Байгууллагын санхүүгийн тайланд хоолны 2,2 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй тайлагнасан бол няравын тайланд 1,3 сая төгрөг тайлагнаж 0,9 сая төгрөгийг зөрүүтэй тайлагнасан байна.
- Боловсрол шинжлэх ухааны сайдын 225/296 тоот тушаалаар баталсан хүүхдийн хоногийн хоолны орц норм, үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээ шаардлагын дагуу хоолны зэс гарган батлуулж баталсан зэсээр хоолыг амч чанартай бэлтгэж өгөх, гал тогооны тоног төхөөрөмжийг сайжруулах шаардлагатай байна. Аудитын хугацаанд бараа мтаериалын тайлангаас түүвэр хийж хянахад чипс, контек, печень, школад, модтой чихэр зэрэг 2,9 сая төгрөгийн хүнс худалдан авч хүүхдийн эрүүл хоололтонд анхаарахгүй байгаагаас үзэхэд хүүхдийн хоолны бараа материалын нийлүүлэлтэнд тавих хяналт сул байна. Түүвэр хийн бараа материалын тайлангаас зарим нэр төрлийн барааны үнийг зах зээлийн жишиг үнэтэй харьцуулахад наранцэцэгийн тосыг 4,0 мян,төг-өөр цагаан будааг 2,5 мянган төгрөгөөр худалдан авсан байгаа нь төсвийн үрэлгэн зардал гаргасан байна.
- Нүүрсний тооцоог галч нараар бодоогүй, зарцуулалтын тайлан гаргаагүй нэг дор бөөн дүнгээр зарлагдаж байгаад хяналт тавьж ажиллах, няравын складын бүртгэл хөтлөөгүй, тайлан гаргалт сул байна.
- Санхүүгийн программыг бүрэн ашиглаагүй санхүүгийн тайлан болон бараа материал, цалинг программаар гаргаж хэвшээгүй байна.
- Багш ажилчидад амралтын дундаж буруу тооцож амралтын цалин илүү олгосонтой холбоотойгоор 1197415 төгрөгийн төлбөр зөрчил илэрсэн тул төлбөрийн акт бичигдлээ.
- 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар махыг зах зээлийн үнээс өндөр үнээр нийлүүлсэнтэй холбоотой 0,4 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдэж төлбөрийг барагдуулаагүй тул 10 сард багтаан барагдуулах үүрэг өгөв.

Гүйцэтгэлийн аудитаар 4,1 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 1,2 сая төгрөгийн акт, 2,9 сая төгрөгийн албан шаардлага бичлээ.

2.7 Сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны талаар:

Эрүүл мэндийн төв нь 2015 онд улсын төсвөөс 211,7 сая төгрөгийн урсгал санхүүжилт авч, ОНХ-ийн сангаас 1,5 сая, өөрийн орлогоор 0,4 сая бүгд 213,3 сая төгрөгийн санхүүжилтэйгээр 20 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулжээ

Иргэдийн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах бодлогын хүрээнд Эрүүл мэндийн төвийн барилгын их засварыг Герман-Монголын хамтын ажиллагаа эрчим хүчний үр ашиг төслөөр 100.0 сая , аймгийн ОНХС-аас 50,0 сая, сумын ОНХС-аас 30,0 сая бүгд 180,0 сая их засвар хийлгэсэн байна.Мөн агуулах, складныхаа дээвэр, барилгын гадна шавардлага зэрэг ажлудыг дээрхи хөрөнгийн эх үүсвэрээр хийлгэж эмнэлгийн байгууллагын ажилтнууд, өвчтөнүүдийн ая тухтай орчинг бүрдүүлсэн байна.

Аудит хийх явцад Эрүүл мэндийн төвийн ажиллагсадтай уулзаж нийт ажиллагсадын 70 хувийг хамруулж 14 ажиллагсадаас нэргүй санал асуулгын хуудсаар санал хүсэлтийг нь авлаа. Санал асуулгын дүнгээс үзэхэд тухайн эмнэлгийг 2015 онд дэвшүүлсэн зорилтоо хангалттай биелүүлж чадсан гэж 80 хувь нь үзсэн бол эргэлтийн эмийн сангийн төсөв хүрэлцэхгүй байгаа, тендерийн эмийн үнэ өндөр, санхүүгийн талаархи гүйцэтгэлийн тайланг танилцуулдаггүй гэсэн 2 асуудалд дийлэнх нь шүүмжлэлтэй ханджээ.

Тус эмнэлэг 2015 оны үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 49 асуудлаар боловсруулж сумын Засаг даргаар батлуулан оны эхэнд нийт ажилчдаараа хэлэлцүүлэн мөрдлөг болгож оны эцэст төлөвлөгөөнд хэлэлцсэн асуудлуудаа 95,6 хувийн биелэлтэйгээр дүгнэгдсэн байна.

Тайлангийн хугацаанд эрхлэгч эмчийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой “А” зэрэглэлийн 28, хөдөлмөрийн харилцаатай холбоотой “Б” зэрэглэлийн 11 бүгд 39 тушаал шийдвэр гарч хэрэгжсэний дээр нийт ажилчдын хурлыг 10 удаа хийж цаг үеийн болон холбогдох асуудлуудыг хэлэлцэн хурлын тэмдэглэл хөтөлж тодорхой шийдвэр гаргаж ажиллажээ.

Ажилтнуудынхаа хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэж ажилчдын хурлаар хэлэлцэж зорилтоо тодорхойлсон байна.

Аймгийн Аудитын газраас 2015 оны санхүүгийн тайлангийн аудит хийсэн дүгнэлтийг сумын удирдлага, эмнэлгийн нийт ажилтнуудад өнөөдрийг хүртэл танилцуулаагүй хариуцсан нягтлан бодох ажилдаа хариуцлагагүй хандсан байна.

Байгууллагад хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж орчин сайжирсан ололттой тал байгаа хэдий ч аудитаар дараахь зөрчил илэрлээ.

- Зах зээлийн үнээс өндөр үнээр хүнсний материал нийлүүлсэн - 493550 төг, нэр бүхий ажилтнуудаас ашгийн татварын хөнгөлөлт тооцож суутгаагүйтэй холбоотой 77000 төгрөг, эрхлэгч эмч Эрдэнэсолонгод илүү цалин олгосон 29627 төгрөг бүгд 600177 төгрөгийн төлбөрийн акт бичлээ.
- Эмнэлгийн галч нарын цалингаас нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй дутагдал байгааг нөхөн төлж цаашид, ажиллах хугацааны цалингаас тогтмол шимтгэл төлж байхыг зөвлөлөө.
- Тус эмнэлэгт хөрөнгө оруулалтаар ирсэн биохимийн анализатор байгаа боловч ашиглалтгүй ч оношлуурын бодисны үнийг эмийн зардлаас санхүүжүүлэх боломжгүй зэргээс тус хөрөнгө ашиглалтгүй хадгалагдаж байна. Зарим сумдын эрүүл мэндийн төвүүд сумын ИТХ-аар оношилгооны эмийн бодисын үнийг худалдан авах өртөгийг нэг иргэнээр тооцон батлуулж орлогоороо зардлаа нөхөн сумандаа чирэгдэлгүйгээр төрөл бүрийн шинжилгээ авч байгаа туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Аудитаар 600177 төгрөгийн төлбөрийн акт бичлээ.

2.8 Сумын соёлын төвийн үйл ажиллагааны талаар :

Соелын төв нь 2015 онд улсын төсвөөс 51,4 сая, өөрийн орлогоор 0,7 сая бүгд 52,1 сая төгрөгийн санхүүжилттэйгээр 7 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа

явуулжээ. Өөрийн орлогын 5,0 сая төгрөгийн төлөвлөгөөтэй бөгөөд орлогын төлөвлөгөө нь 14,2 хувийн биелэлттэй байна.

Соёлын төвийн захирлаар 2013-2016 оны 10 дугаар сар хүртэл Х.Баярсайхан ажиллаж байсан ба 10 сараас Д.Одонтүяа шинээр томилогдон ажиллаж байна.

Тус төв нь оны эхэнд сар, улирал, жилийн ажлын төлөвлөгөө гаргаж ЗДТГ-ын даргаар батлуулан тайлант хугацаанд урианхай үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх, өвлүүлэх Алтан өв хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд түүхэн болон тэмдэглэлт баяр ёслол, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх талаар албан байгууллага баг, иргэдийн оролцоотой олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

Гэвч тус соёлын төв нь өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулахад шаардлага хангахуйц соёлын төвийн барилгагүй шахам хуучин соёлын төвийн барилгадаа нүүж орсон байдалтай байна. Хуучин соёлын төвийн барилга нь 1991 онд стандартын дагуу баригдсан караказан барилга бөгөөд ашиглалтын хугацаа дуусаагүй байхад дараахь байдалтай байна.

- Барилгын том заалны хэсэг суулт үүсэж ан цав үүссэн
- Тайзны шал, нүүр, дээвэр зэргийн бүх банз ислэг хавтанг хуулж авсан
- 5 ширхэг хаалгыг кроптойн сугалж авсан
- Урианхай түмний өв соёл, зан заншлыг сурталчилах суртчилгааны самбар, үндэсний хувцас зэргийг байрлуулсан танхим байсан нь самбаруудыг буулгаж хураасан, хувцаснуудыг шороотой сейфенд бөөнөөр нь чихэж хадгалсан
- Бүх цонх хагархай шувуу шаазгайны өд сөдөөр дүүрсэн, зарим өрөөнүүдэд нь хувь иргэдийн өвс агуулсан зэрэг ер нь балгас болон хувирсан байна. Иймд байгууллагын хөрөнгийн ашиглалтанд тавих хяналтыг сайжруулж тус барилгыг хэрхэх талаарх шийдвэрийг яаралтай гаргуулах шаардлагатай байна.

Аудитаар акт , албан шаардлага илэрсэнгүй. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллах нэгдсэн албан шаардлага өгөгдлөө.

2.9 Сумын эмийн эргэлтийн сангийн талаар:

2008 оны 10 дугаар сард Засаг даргын захирамжаар эмийн эргэлтийн сангийн эрхлэгчээр томилогдсон Б.Ариунэрдэнэ сумын эрүүл мэндийн төв болон иргэдийг эмээр хангах үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

Эмийн эргэлтийн сан нь Эрүүл мэндийн сайдын 2011 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 297 тоот тушаалын хавсралтаар “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-аар зохицуулагдаж байна.

Энэ журмын 2.2-т “Бүх шатны Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд удирдах болон хяналтын зөвлөлийн тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна” 2.1-д...”суманд ЭЭС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий хяналтын зөвлөл байна.” 4.5.1-т “ЭЭС-ийн эрхлэгч нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай боломжийн үнэтэй эм, эмнэлгийн хэрэгслэлээр сумын эрүүл мэндийн төв, ард иргэдийг хангана” гэж заасан байна. Аудитын шалгалтын хугацаанд

сумын ЭЭС-ийн санхүүгийн анхан шатны баримтууд татварын шалгалтанд хамрагдаж байгаа тул хамрагдсангүй.

Тус эмийн эргэлтийн сан нь даатгалын сангаас авах санхүүжилт, тендерийн эм барьсны орлого, иргэдэд эм борлуулсаны орлогоос сумын иргэдэд эм эмнэлэгийн хэрэгсэлээр ханган тусламж үйлчилгээг үзүүлж байгаа тул эмийн эргэлтийн сангийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцаас сумын төрийн төрийн санд олгож Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий санхүүгийн дотоод хяналтыг төсвийн шууд захирагч нар болон төрийн сангийн төлөөлөгч хэрэгжүүлж хяналт тавьж ажиллаж байна.

Сумын Төрийн сангийн мэргэжилтэний гүйлгээг хянахад сар бүрийн мемориалийн баримтыг дараалалын дагуу үдсэн, баримтыг стандартын дагуу архивласан боловч төрийн албан ёсны хэлээр төрийн ажил үйлчилгээг хөтлөөгүй галиглан бичсэн байна.

Сумдын нийт байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан 1 төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлан, 4 төсвийн шууд захирагчийн тайлан бүгд 5 тайлан “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан үзэхэд санхүү бүртгэлд тавих хяналт сумын хэмжээнд хангалтгүй дүгнэлт авчээ.

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг shilendans цахим хаягаар оруулах үүргийг төсвийн байгууллагуудын захирал, нягтлан бодогч нар хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг хянахад туйлын хангалтгүй байна. Хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

№	Мэдээллийн төрөл	Сургууль	Цэцэрлэг	Эмнэлэг	Соёлын төв	ИТХ	ЗДТГ
1	Дараа жилийн төсвийн төсөл	мэдээлээгүй					
2	Батлагдсан төсөв	1-9 сар мэдээлсэн боловч тайлбар мэдээлээгүй					
3	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт	1-10 сар мэдээлсэн боловч өөрчлөлт байхгүй гэж мэдээлсэн					
4	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт	мэдээлээгүй					
5	5 саяас дээш орлого зарлага	мэдээлээгүй		байхгүй гэж мэдээлсэн		мэдээлээгүй	
6	Санхүүгийн тайлан	мэдээлээгүй					
7	Аудитын дүгнэлт	мэдээлээгүй					
8	ХАА-ны төлөвлөгөө	мэдээлээгүй					
9	Концесс	байхгүй гэж мэдээлсэн					
10	Тендер	байхгүй гэж мэдээлсэн	мэдээлээгүй	мэдээлээгүй	мэдээлээгүй	мэдээлээгүй	байхгүй гэж мэдээлсэн
11	5 саяас дээш ХАА	байхгүй гэж мэдээлсэн	байхгүй гэж мэдээлсэн	мэдээлээгүй	мэдээлээгүй	мэдээлээгүй	мэдээлээгүй
12	ХАА-ны тайлан	мэдээлээгүй					
13	НАНБХАШЗТ хуулийн 8, 9 зүйл	мэдээлээгүй					
14	Төлбөр хураамж	байхгүй гэж мэдээлсэн					
15	Батлагдсан орон тоо	мэдээлээгүй	мэдээлээгүй	байхгүй гэж мэдээлсэн	байхгүй гэж мэдээлсэн	байхгүй гэж мэдээлсэн	мэдээлээгүй
16	ХАА-ны аудитын тайлан	мэдээлээгүй					
	ДҮН	хангалтгүй	хангалтгүй	хангалтгүй	хангалтгүй	хангалтгүй	хангалтгүй

Дээрх хүснэгтээс харахад мэдээлэлийг Шилэн дансны сайтад байршуулах, мэдээлэх эрх бүхий албан хаагчид хуульд заасан чиг үүргээ биелүүлээгүй байгаа тул сумын Төсвийн Төвлөрүүлэн захирагчид албан шаардлага бичлээ.

Орон нутгийн олон нийтийн ТВ /Ховд ТВ/, Орон нутгийн сонин /Ховдын толь сонин/, танилцуулга, бусад олон нийтийн ажил, уулзалт, сургалт, багуудын хурлаар дамжуулан сум орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалт, санхүүжилт, ажлын гүйцэтгэлийн талаар олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Мэдээлэлийн технологийн эрин үед хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг иж бүрэн ашиглах шаардлагатай байна.

Тус суманд мэдээлэл түгээх үүрэн холбооны сүлжээ өргөн тархсан, байгууллагуудын төсвөөс интернетийн модем худалдан авч нөөц бүрдэж сумдын байгууллагууд цахим сүлжээнд холбогдсон зэргээс үзэхэд цахим мэдээлэлийг тухай бүр ашиглах боломжтой болжээ.

Сумын бүх төсөвт байгууллагууд санхүүгийн программ хангамж ашиглаж байгаа боловч бараа материалын тайланг иж бүрнээр программд оруулдаггүй, цалинг программ хангамж ашиглан боддоггүй зөрчил байна.

Аудитаар нийт 23,543,772 төгрөгний төлбөр зөрчил илэрсэнээс 4,663,634 төгрөгийг актыг аймгийн төсөвт төвлөрүүлэх, 217,838 төгрөгийг буцаан олгох, 18,123,300 төгрөгт албан шаардлага бичигдлээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Тус сумын орон нутгийн төсөвт байгууллагууд 2015 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэн ажилласан сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд илэрсэн төлбөр, зөрчилд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтануудад зөвлөмж болгон хэрэгжүүлж байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Г.Цэвэлмаа, Засаг дарга Д.Таванцэрэг нарт

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, зээлээ графикт хугацаандаа төлөөгүй, зориулалт бусаар зарцуулж буй иргэдийн зээлийг буцаан татаж зээлийн эргэлтийг нэмэгдүүлэх
- Орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийн ашиглалт, эзэмшилт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулах
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн ханган ажиллах

Сургуулийн захирал Х.Оюунгэрэлд

- Сургуулийн биеийн тамирын заалны шалны хөрөнгө оруулалтын асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлж сургалт хүмүүжлийн ажлын тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах
- Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, жижүүр багшийн ирцийн бүртгэлд сургуулийн удирдлага болон эмч, санхүүгийн ажилтны тавих хяналтыг сайжруулах, холбогдох албан тушаалтны ажлын хариуцлагыг дээшлүүлэх
- Тогоочийн зэргийн нэмэгдэл болон жижүүрийн илүү цагийн хөлсийг батлагдсан төсөвт багтаан олгох
- Бараа материалыг зах зээлийн үнэ ханшаар худалдан авах, эд хариуцагчийн тайланг сар бүр гаргаж бүртгэлээр тавих хяналтын сайжруулах
- Үр дүнгийн урамшуулал болон ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгохгүй ажлын үр дүнтэй нь уялдуулан олгох

Сумын цэцэрлэгийн эрхлэгч Х.Мөнхтуяа:

- Багш ажилчдад ажлын үр дүнг харгалзан ур чадварын нэмэгдэл, илүү цаг, үр дүнгийн нэмэгдлийг олгож төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж ажиллах
- Хүүхдийн хоолны амт чанар, хоолны илчлэг, нэр төрөлд анхаарч БСШУСайдын 225/296 тоот тушаалаар баталсан хоолны норм, үндсэн шимт бодисын илчлэгийн хэрэгцээг мөрдөж ажиллах, хүүхдийн хоолны ирц, чанар, үнэнд тавих дотоод хяналтыг сайжруулах
- Бараа материалыг зах зээлийн үнэ ханшаар худалдан авах, эд хариуцагчийн тайланг сар бүр гаргаж бүртгэлээр тавих хяналтын сайжруулах

Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч Б.Эрдэнэсолонгод:

- Төлбөртэй үйлчилгээний орлогыг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж иргэдэд үйлчилгээг хүргэн яаралтай оношилгоо хийдэг ажлыг нэвтрүүлэх
- Бараа материалыг зах зээлийн үнэ ханшаар худалдан авах, эд хариуцагчийн тайланг сар бүр гаргаж бүртгэлээр тавих хяналтын сайжруулах

Сумын соёлын төвийн эрхлэгч Д.Одонтуяа:

- Байгууллагын хуучин байрны асуудлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх
- Үнэт цаасны тооцоог сар бүр хийж үлдэгдэлийг баталгаажуулан, тайз ашигласан шимтгэлийн орлогын мөнгө хураасан баримтыг дарга, нягтлан бодогч, няравын гарын үсгээр баталгаажуулж баримтжуулах

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АХЛАХ АУДИТОР

Д.НАРАНТУУЛ

ШИНЖЭЭЧ

Ц.ГАНТУЛГА

ШИНЖЭЭЧ

Ц.АЗЗАЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 33

Ховд хот

Аудитын тайлан, зөвлөмж, акт,
албан шаардлага батлах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 тоот тушаалаар баталсан "гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2, 2009 оны 47 тоот тушаалаар баталсан "төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1 дэх заалт, аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын дэргэдэх зөвлөлийн 2016 оны 11 сарын 01-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Дуут, Мөст сумдын төсөвт байгууллагуудын 2015 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, зөвлөмж, акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Дуут сумын Засаг дарга Д.Таванцэрэг-д ДААЛГАХ нь:

2.1 Сум хөгжүүлэх сангийн зээлийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, зээлээ графикт хугацаандаа төлөөгүй, зориулалт бусаар зарцуулж буй иргэдийн зээлийг буцаан татаж зээлийн эргэлтийг нэмэгдүүлэх

2.2 Орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийн ашиглалт, эзэмшилт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулах

2.3 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн ханган ажиллах

3. Мөст сумын Засаг дарга С.Баасандорж-д ДААЛГАХ нь:

3.1 Тус сумын хэмжээнд бүртгэлтэй боловч байхгүй байгаа 131 авто тээврийн хэрэгсэл байхгүй мөртлөө татварын төлөвлөгөөнд тусгагдаж байгааг судлаж шийдвэрлэх

3.2 СХСангаас авсан зээлээ бүрэн төлөөгүй байгаа иргэдээс зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл болох 64,4 сая төгрөгийг төлүүлэн авч дараагийн зээлдэгч нарт олгох

3.3 Биссет компани, Лото блок компанийн түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрийг тооцож төсвийн орлого болгох

3.4 Хууль бус 1,9 сая төгрөгний нэмэгдэл цалин авсан алба хаагчдын нэмэгдлийг зогсоох

4. Гүйцэтгэлийн аудитын зөвлөмж тавьсан акт, албан шаардлагыг барагдуулж дүнг 11 сарын 25-ны дотор танилцуулахыг аудит хийсэн аудитор, шинжээч нарт хариуцуулсугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ГАЛБАДРАХ

